



Бурхан бүхнийг зохицуулдаг

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдсан билиг ухааны зурагт үлгэрүүд

Бурхан Бүхнийг Зохицуулдаг




Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн
айлдсан билиг ухааны зурагт үлгэрүүд

БУРХАН БҮХНИЙГ ЗОХИЦУУЛДАГ

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн
айлдсан билиг ухааны зурагт үлгэрүүд





*Бурхны Хаант улс бол алт, мөнгө, алмаз,
бадмаарга зэрэг төрөл бүрийн эрдэнийн чулуугаар
чилсэн ордон биш билээ. Энэ бол цэвэр ариун
байдал, хайр нинжин сэтгэл, энэрэл нигүүлсэл,
дотгоод амар амгалан байдал юм.*

*Бурхны Хаант улс гэдэг нь энэ л юм.
Хэрэв бид энэхүү Бурхны Хаант улсыг дотгооддоо
агуулж явбал, хаана ч очсон Диваажинд байгаа
мэт санагдах болно.*

--- Төгс Гэжээрсэн Их Бааш Чин Хай ---



Нэгэн Аугаа Их Багшийн Түүх

”Гэрэлт, гэрэлт бяцхан од минь, чамайг юу юм бол гэж би хэчнээн их гайхдаг гээч”. Чи үдшийн тэнгэрийг хараад тийнхүү сониучирхаж үзсэн үү? Хэн энэ гайхалтай оддыг бүтээсэн юм бол оо? Олон жилийн өмнө нэгэн хөөрхөн жаахан охин яг л ингэж гайхаж бодлогоширдог байсан гэнэ. Одод түгсэн тэнгэрийн сүр жавхланг хараад, бүтээгчтэй нь уулзах юмсан гэж тэр бяцхан охин маш их хүсдэг байжээ. Түүний нууцхан хүсэл болсон тэр мөрөөдлөө бяцхан охин маань зүрх сэтгэлдээ нандигнасаар иржээ. Тэгээд, олон жил хаа сайгүй Бурханыг хайсны эцэст Түүний мөрөөдөл биеллээ олжээ. Тэр оддыг бүтээгчтэй уулзсан гэнэ!

Тэр бяцхан охин маань зүүн өмнөд Азийн Аулак хэмээх улсад мэндэлжээ. Тэр бага балчраасаа оддыг Бүтээгчид хандан “Намайг Таныг

харахыг зөвшөөрөөч” хэмээн гуйдаг байжээ. Түүний хүсэл нь олон жилийн турш биелэгдэхгүй байсан боловч тэр хэзээ ч шантарч байгаагүй. Тэр итгэлээ хадгалан залбирсаар л байж гэнэ. Тэр эцэг эхтэйгээ хамт Есүсийн сүмд очиж, эмээтэйгээ хамт Буддын сүмд залбирдаг байжээ. Тэр мөн хүмүүст яаж Бурхныг олох тухай зааж өгдөг олон агуу ном судруудыг уншсан гэнэ. Тэрээр, хааяа энэхүү ариун ном судрыг уншиж байгаад цээжиндээ тэврээд унтаад өгчихдөг байсан ажээ.

Энэ бяцхан охин маань учирсан хүн бүртэй нинжин сэтгэлээр ханддаг байсан гэнэ. Ядуу хүмүүсийг энэрэн хайрлаж байсан учир тэр гэртээ байгаа жаахан ч атугай хоол хүнс, мөнгө өгөх арга саам эрэлхийлдэг байсан ажээ. Түүний үнэнхүү тусч сайхан сэтгэл ойр дотны таньдаг мэддэг хүмүүсийн зүрх сэтгэлд хайрыг бадраажээ.

Бяцхан охиныг өсч том болоод үзэсгэлэнт сайхан бүсгүй болоход аав нь Түүнийг Англи улс руу сургахаар явуулж гэнэ. Хэл сурах авьяастай учир Тэр богинохон хугацаанд Англи, Герман, Франц хэлнүүдийг сурав. Тэр ядарсан хүмүүст чадлаараа тусалсаар л байлаа. Тэр бас хэзээ ч, нэг ч хором өөрийн хүсэл мөрөөдлөө мартсангүй.

Хэсэг хугацааны дараа Тэр нэгэн Герман эмчтэй гэрлэсэн ажээ. Нөхөр нь маш зөөлөн сэтгэлтэй хүн байсан бөгөөд тэд хамтдаа хоёр жил аз жаргалтай амьдарчээ. Тэгэхдээ Түүний өөрийнхөө төлөө төдийгүй золгүй нэгэнд үнэнхүү ач тустай болохын төлөө Бурхныг хайж олох гэсэн хүсэл Түүний зүрхэнд оргилсоор байв. Тиймээс, нэгэн өдөр нөхрийнхөө зөвшөөрлөөр Тэрээр ганцаараа Бурхныг хайхаар явжээ.

Аяллынхаа дараагийн хэсэгт Энэтхэгийг оролцуулан алс холын нутгийг Тэрээр зорьсон байна. Тэр тэгж явсаар алс холын, цас мөсөнд дарагдсан Гималайн Ууланд өөрийг нь Арьяабалын бясалгалын арга хэмээх эртний сүнслэг дадалтай нэвтрэлцүүлж өгөх нэгэн Гэгээрсэн Багшийг олжээ.

Тэр Арьяабалын Аргыг хүлээн авч диваажны Гэрэл, Аялгууг ажиглан бясалгаж, Бурхантай нүүр тулж, өөрөө Бурхантай нэгэн цогц болж гэнэ. Энэхүү гэгээрсэн байдалд түүний дотоод сүнс зөвхөн одод хүрээд зогсолгүй, тэр оддоос ч холоо даван гарч чаджээ.



Түүнийг Бурхан маш өндөр түвшний Диваажинд аваачжээ. Тэгээд Тэр өөрөө Агуу Их Багш болжээ.

Тэр Гималайд нэлээд олон сар болсны дараа уулнаас буухад бэлэн болж гэнэ. Удаж төдөлгүй Тэр Хятадад ойр орших үзэгсэлэнт Формоса арал дээр ирсэн ба бага багаар энэхүү гайхалтай Арьяабалын аргыг бусадтай хуваалцаж эхэлжээ. Тэр үеэс эхлэн хүмүүст энэ аргаар Бурхантай дахин холбогдоход туслахаар дэлхий даяар аялжээ. Олон хүн гэгээрэлд хүрсэн ба тэдний сүнс ч бас одод, диваажингуудад мөн тэрнээс ч чанагш гарсан байна.

Тэрээр одоо Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай хэмээн олонд алдаршсан юм. Гэвч Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай биднийг бүгдээрээ Бурхны үр сад учраас бүгд их багш нар гэдэг. Хэрэв бид аргаа мэддэг бол Бурхныг хүссэн цагтаа харж, Түүнтэй ярилцаж болох юм.

Их Багш Чин Хай Арьяабалын аргыг заагаад зогсохгүй бас зураг зурж, дуу зохиож, хөгжмийн зэмсэг тоглож мөн гоёмсог хувцасны болон үнэт эдлэлийн загвар зохиодог. Тэрээр мөн үлгэр их сайхан ярьдаг бөгөөд онигоо ярих маш дуртай. Тэр хүмүүсийн дунд үргэлж их инээдэм наргиан болж байдаг.

Тэр бага байхдаа хүмүүсийг халамжилдаг байсан шигээ одоо ч тусалсаар байгаа бөгөөд хүүхдүүдэд маш их хайртай. Тэр хэлэхдээ хүүхдүүд Бурхантай том хүмүүсээс илүү ойр байдаг гэжээ. Бурхныг харахын тулд бид бүгд хүүхэд шиг болох хэрэгтэй гэдгийг Тэр сануулдаг юм.

Та бүхэн нэгэн бяцхан охины Бурхныг харах хүсэл биелснийг мэдлээ. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай чадсан юм чинь, бид ч бас чадна. Чамд Түүнийх шиг хүсэл мөрөөдөл бий юу?

Бяцхан илгээмж:



Сүнслэг их багш, уран бүтээлч, загвар зохион бүтээгч Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай дотоодын гоо сайхныг илэрхийлсэн бүхий л зүйлд дуртай байдаг юм. Тиймээс ч Тэр Вьетнамыг “Ау Лак”, Тайваныг “Формоса” хэмээн нэрлэдэг. Ау Лак гэдэг нь эртний Вьетнамын нэр бөгөөд “аз жаргал” гэсэн утгатай. Формоса хэмээх “үзэгсэлэнтэй” гэдэг үг нь Тайван арлын байгаль болоод ард түмнийх нь гоо үзэмжийг илүү бүрэн дүүрэн илэрхийлсэн. Эдгээр нэрсийг ашиглах нь тухайн нутаг орон, ард түмэнд нь аз жаргал, сүнслэг дэвшил авчирна гэж Их Багш үздэг юм.



Бид энэхүү хүүхдийн зүрх сэтгэлээ хадгалбал, хичнээн хөширлөө ч Бурхны хүүхдүүд хэвээр байх болно. Бид там руу явахгүй, эсвэл ямар нэг таагүй нөхцөл байдалтай тулгарахгүй бөгөөд бидний амьдрал маш урсам зөөлөн байх болно. Ядаж л зүрх сэтгэл маань үүрд аз жаргалтай байх болно. Бид нээлттэй байж, асуудлууд, саад бэрхшээлүүдэд тэйтлээ хямарч, бухимдахгүй. Бид сэтгэл амар байж, бодол санаандаа ямар ч хүлээс даралтгүй байх болно. Хүүхдийн зүрх сэтгэл гэдэг бол энэ. Нас бие үйцсэний дараа эргээд хүүхэд болох боломжгүй гэдэг хурдаа юм.

--- Төгс Гэгээрсэн Их Бааш Чин Хай ---



*Бусдыг ойлгож, хайр, нинжин сэтгэл, тэсвэр тэвгээрээр
хандах бүрдээ бид Диваажинг бүтээж байдал.*

--- Төгс Гэгээрсэн Их Бааш Чин Хай ---

Өмнөх үг

Энэхүү зурагт үлгэр нь бүх насныханд зориулагдсан бөгөөд энэ нь Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн ярьсан хорин сэтгэл хөдлөм онцгой үлгэрээс бүрдсэн юм. Амьд, хөгжилтэй шог зураг болон бичвэрээр илэрхийлэгдсэн эдгээр үлгэр бүр нь уншигчид хүрч, зүрх сэтгэлийг нь аз жаргалаар бялхаам арвин сургамжтай гүн гүнзгий утга агуулгаар дүүрэн билээ.

Сонирхолтой, хөөр баяслаар дүүрэн сургаалт үлгэрүүд нь багачуудыг бодох, ухаарах болон төсөөлөх ур чадвараа хөгжүүлэх урам хайрлах болно. Эдгээр шог зурган өгүүллэгүүд нь дээд үнэнийг ойлгоход хялбар аргаар хүргэж байгаа учраас хүүхдүүдэд Үнэнийг баяр хөөртэй, тайван байдлаар олж мэдэн, шингээж авах боломж олгож буй юм. Бидний өнөөгийн төвөгтэй, ээдрээтэй мэдээлэлтэй орчинд энэхүү нандин цуглуулга нь хүүхдүүдийн тань бодол болоод сэтгэлийг Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн хошигнол, билиг ухаанаар тэтгэх болно.





Агуула

Нэгэн Агуу Их Багшийн Түүх	04
Өмнөх үг	09
1. Ах дүү хоёр ба одон жимсний мод	13
2. Зодоонч азарган тахиан үлгэр	21
3. Бурхан үргэлж бүхнийг хамгийн сайнаар зохицуулдаг	24
4. Бусдыг хайрлах нь өөрсдийгөө хайрлаж буй юм	29
5. Ялгаваргүй хайрла	32
6. Жинхэнэ эрдэнэ	36
7. Хулгайч бясалгагч болсон нь	39
8. Энэрэнгүй сэтгэл ба хатуу сэтгэл	44
9. Самурайн урлаг	49
10. Бурхан бүхнийг зохицуулдаг	52
11. Хөл толгойгоо алдсан энэ дэлхий	56

Бяцхан илгээмж:

Эзэн Бурхан болоод Дээд Сүнсний тухай ярихдаа Эзэн Бурхан эр эсвэл эм хүйстэй аль нь болох маргаанаас зайлсхийх үүднээс хүйсийн ялгаа заадаггүй, анхдагч нэр томьёо ашиглаж байхыг Их Багш бидэнд зөвлөсөн юм.

She + He = Hes (Bless гэдэгтэй адил дуудна)


Her + Him = Hirm (Firm гэдэгтэй адил дуудна)

Hers + His = Hiers (Dear гэдэгтэй адил дуудна)

Жишээлбэл: Бурхан хүсвэл, юмыг Тэрээр (Hes) Өөрийн (Hirmself) тааллаар, Түүний (Hiers) хүсэл зоригт нийцүүлж хийдэг юм.

12. Бүх зүйл бодлоос үүдэлтэй.....	59
13. Оюун ухаанаа сайн ашигла	62
14. Мунхаг ханхүү	66
15. "Би" үзлийн сорилт	70
16. Сэтгэлийн огоорол л чухал	73
17. Их Багшийн гадаад үйлдлийг бид дуурайх учиргүй.....	78
18. Зочдыг үргээх мэргэн арга.....	81
19. Хөгшин гуйлгачин эмэгтэйн билиг ухаан	83
20. Ши Гонгийн лууг гэх хайр	87
Иш татсан эх сурвалжуудын жагсаалт	91
Хэвлэгдсэн номнууд.....	93
Бидэнтэй хэрхэн холбогдох вэ	104






*Бурхан бол хаа сайгүй тархсан хайр юм. Тиймээс
аливаа бүхнийг хайраар хийх бүрд Бурхан бидэнд
туслах болно.*

--- Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай ---

АХ ДҮҮ ХОЁР БА
ОДОН ЖИМСНИЙ МОД






Эртээ урьдын цагт нэгэн ядуу айлын хоёр хүүгийн том нь ертөнцийн асуудлуудад их заль мэхтэй харин бага хүү нь их энгийн даруу, ер нь жаахан мулгуу ч юм шиг мөртлөө их ариун сэтгэлтэй, Бурханд бат итгэлтэй нэгэн байжээ.



Хэсэг хугацааны дараа тэдний эцэг, эх хоёр нь таалал төгсч, тариалангийн талбай болон хэсэг өмч хөрөнгө үлдээжээ.

“Би бүх өмч хөрөнгөө хариуцъя. Угаас чи эхнэр хүүхэдгүй, өмч хөрөнгө хариуцаж чадахгүй учраас чамд зөвхөн ганцхан ширхэг одон жимсний модыг өгье, за юу?”



Тэгье, том ах аа.

Дүү нь өдөр болгон хичээнгүйлэн ажиллаж гэнэ.





Тэгээд, одон жимсийг боловсрохоор, түүж авч зараад мөнгө олжээ. Мод нь том байсан учраас маш арвин жимс өгчээ.



Зарагдаад үлдсэн жимсээрээ тэр одон жимсний шүүс хийж, мөн заримыг нь даршлав.



Түүний олсон мөнгө нь амин зуулганд нь хүрэлцэж, тэр аливаад амархан сэтгэл ханамжтай болдог байв.



Нэг өдөр, тэр жимсээ даршлахад хэрэгтэй зарим нэг хүнсээ авахаар явжээ.



Гэртээ буцаад иртэл...



Нэг хэрээ модон дээрхи жимсний тэн хагасыг нь идчихсэн байв.



“Чи яагаад миний одон жимсийг идсэн юм бэ?”

“Би өлсөөд байсан юмаа.”



Хэрээ түүнд авахыг хүссэн бүх эрдэнэсээ
уугандаа хийгээрэй гэж хэлэв.



Тэгээд уут дүүрсний дараа
хэрээ түүнийг гэрт нь хүргэв.



Үүний дараа бага дүү нь
маш баян болж, шинэхэн
байшин барин үзэсгэлэнт
эхнэртэй болжээ.



Түүнийг гэнэт баян
болсныг нь сонсоод
ах нь уулзахаар
ирж гэнээ.



Тэр ахдаа
болсон бүх
явдлаа ярьж
өгөв.

“Ийм их буян хишиг миний чамд өгсөн одон жимсний модноос үүдэлтэй. Тиймээс, одоо би модыг арчилъя, харин чи миний байранд оч.



“Тэгье, том ах аа.”

Өдөр бүр, том ах нь модны сүүдэр дор дүүжин орон дээр тухлан хэвтэж хэрээ ирэхийг хүлээнэ.



Тэр зөвхөн алт эрдэнэсийг л мөрөөдөж байв. Нэг өдөр, энэ нь үнэхээр биелэлээ олж гэнэ...



Нэг хэрээ одон жимсийг идэхээр иржээ. Том ах нь бага дүүгээ дуурайн ерөвдөлтэй дур эсгэжээ. Хэрээ бас түүнд маргааш алт лавахуулахаар хүргэж өгье гэж амлажээ.



Тэр хэрээтэй уулзах цагаасаа хамаагүй түрүүнд ирээд, аварга том ууттай хүлээж байв.



“Чи аяллын туршид нүдээ нээж, ярьж болохгүй шүү.”





Далай дээгүүр нисэхэд нь тэднийг маш хүчтэй шуурга дайрав.

Хэрээ хамаг чадлаараа тэнцвэрээ олох гэж хичээсэн боловч салхи их хүчтэй байлаа.

“Хүүе, чи ингээд гуйвж савчаад байх юм бол би унах нь.”



Шуналтайгаар тэр хэтэрхий их эрдэнэс авчээ, тэгээд түүнийг нүдээ нээн ийнхүү ярихад, ид шид хүчингүй болж тэрээр эрдэнэсийн хамт далай руу унажээ.

Хэрэв хүн хэтэрхий шунахай байвал, заримдаа юу ч үгүй хоцордог.



Зодоонч азарган

тахуан үлгэр





Азарган тахиан зодоонд маш их дуртай Хятадын нэгэн хаан байжээ.

Тэр нэгэн чадвартай сургагчийг хамгийн сайн үүлдрийн азарган тахиаг ирээдүйн аварга болгон дасгалжуулхаар томилв.




Бүтэн сарын хугацаа өнгөрсний дараа хаан азарган тахиагаа зодолдоход бэлэн болсон үгүйг мэдэхийг хүсжээ.

“Үгүй, арай л болоогүй байна. Тэр ямар нэгэн өөр азарган тахиаг хараад л, бүр маш хол байсан ч хамаагүй их хөөрч өөрийгөө гайхуулж эхэлдэг. Тэр бэлэн болоход бүр яагаа ч үгүй байна.”



Дахин бүтэн сар өнгөрсний дараа хаан: “Одоо тэр бэлэн болов уу?”

“Арай болоогүй, гэвч дээрдэж байна” гэж тахиа сургагч хариулжээ.



Нэлээд олон сар өнгөрсний дараа хаан залхаж, хэнд ч хэрэггүй тэр азарган тахианы тухай мартсан байв. Гэтэл нэг өдөр, тахиа сургагч хаанд бараалхан.

“Одоо тэр бэлэн боллоо.”

Яагаад тэр билээ? Бэлэн болсныг нь чи яаж мэдэж байгаа юм?



“Учир нь тэр одоо зодоонч азарган тахиа шиг харагддаггүй, гэвч бусад бүх азарган тахианууд түүнээс айдаг! Тэр одоо маш хүчтэй болсон.”

Бүх хүч бүрдсэний дараа энэ нь мэдэгддэггүй. Тийм болсныг нь мэдэх боломжгүй. Тийм учраас олон сударт: “Төгс гэгээрэлд хүрсэн хүн маш энгийн байдаг. Энгийн сэтгэл бол гэгээрсэн сэтгэл.” гэж бичсэн байдаг.



Бурхан үргэлж бүхнийг
хамгийн сайнаар зохицуулдаг





Нэгэн хаан, итгэлт зөвлөхийнхөө хамт эгэл жирийн ард болж зүсээ хувирган аж байдлыг илүү сайн ойлгохын тулд ард иргэдийнхээ дунд орохоор гарч явжээ.



“Миний бие өлсөж байна. Чамаас идэх юм олж ирэхийг хүсье.”

“За, Хаантан минь.”

Зөвлөх манго жимс түүж хаанд өргөн барьжээ.



Хаан хутга аван мангог арилгаж эхлэв.

Санаандгүйгээр тэр хуруугаа зүсчихэж гэнэ.

“Яанаа надаас цус гарч байна.”



*Энэтхэгт зарим хүмүүс Кали хэмээх ариун дарь эхийг шүтдэг. Домогт өгүүлснээр бол Кали нь сөрөг муу, сүйрлийн дарь эх аж. Эрт дээр үед түүнээс маш ихээр айдаг мухар сүсэгтэй хүмүүс байсан ба тэд түүнд амьд өргөл өргөх ёстой гэж боддог байжээ.





Бусдыг хайрлах нь
өөрсдийгөө хайрлаж буй юм





Эрт урьдын цагт, ядуу зүдүү хүмүүст бараг л өглөг өгдөггүй, өөрийн хүндтэй байр сууриндаа жаргал эдлэхээ л боддог маш хөрөнгөтэй нэгэн хаан байжээ.



Нэг өдөр тэр нас бараад хорвоог орхиж гэнэ.

Тэр өлсөж байсан ч, идэх юм юу ч байсангүй.



Хааны өлсөж цангах нь тэсэхийн аргагүй болов.



Тэр маш үзэсгэлэнт алтан ордонд иржээ.



Тэр тэнгэрийн элчид гомдол мэдүүлж гэнэ:

“Энэ чинь ёстой утгагүй юм байна. Яагаад миний гэрт идэж уух юм байдаггүй билээ?”



“Чи амьд байхдаа, хүмүүст ямар нэгэн юм өгч байсан уу? Чи өлбөрч үхэх гэж байгаа гуйлагчдад хоол өгч байсан гэж үү?”

“Чи хэзээ ч хүмүүст хоол өгч байгаагүй болохоор, одоо чамд хэн ч хоол өгөхгүй. Юу тарина, түүнийгээ хураана.”

“Би яахаараа тэдэнд хоол өгөх ёстой юм? Тэд чинь өөрсдийн үйлийн үрээр гуйлагчин болсон шүү дээ?”



“Ай халаг! Тэгвэл, одоо яадаг билээ?”

“Чамд зөвхөн дахин хүн болохоо хүлээх л сонголт байна. Тэр үед чи наашаа буцаж ирэхдээ идэх хоолтой байхын тулд, өглөг буян сайн үйлдэх хэрэгтэй.”



“Танаас гуйж байна. Та намайг богинохон хугацаанд хүний ертөнцөд очихыг зөвшөөрөөч. Би тэнд байх хугацаандаа өөрийн бүх эд хөрөнгийг бусдад өгье. Эс тэгвээс, би энд өлбөрч, мөн үүний төлөө юу ч хийж чадахгүй юм байна.”

Тэнгэрийн элч түүнийг өрөвдөн, ерөөс тийм айхтар муу зүйл хийгээгүйг нь бодож үзэн буцахыг нь зөвшөөрчээ.



Хаан буцаж дэлхийд ирээд бүх эд хөрөнгөө бусдад өгчээ, хүмүүс юу л авъя гэнэ тэрнийг нь өгчээ. Зөвхөн тэгж байж л тэр дараа нь диваажинд шагналаа хүртэж чадахнээ!

Ертөнцийн бүхий л эд баялагаа тарааж өгөх нь ач холбогдол багатай адислалт шагнал хүртэх ба, энэ нь хэдийгээр Бурхантай нэг болох агуу шагналтай харьцуулшгүй ч гэлээ бид бусдыг аз жаргалтай болгохгүйгээр өөрдсөө хэзээ ч аз жаргалтай болж чадахгүй.



ЯЛГАВАРЛАХГҮЙ ХАЙРЛА



Худалдаа наймаа нь уналтанд орсон нэгэн эр байжээ.



Тэр заримдаа өөрийн нэгэн нэн ядуу хөрш болох Үнэнийг бясалгагчид маш жаахан хоол хүнс, мөнгө өгдөг байв.



Хажуу айлын бясалгагчдаа илүү өгөх тусам түүний эрхэлдэг ажил болон гэр бүл нь улам сайжирсаар л байлаа.



Хэсэг хугацааны дараа.

“Ай, энэ хүнд би юм өгөх тусам ажил минь бүтэмжтэй байна. Ингэхэд Багш нь түүнээс сая дахин чадалтай гэж сонссон юм байна.”




Тэгээд тэр маш их нандин бэлэг бэлдэж, хөршийнхөө Багшийг олохоор явжээ. Түүнээс хойш тэр зөвхөн Багшид нь л өглөг өгч, хөршдөө юу ч өгөхөө больжээ.



Тэгтэл хэсэг хугацааны дараа, түүний ажил хэрэг тогтворгүй, өдөр ирэх тусам дордсоор л байлаа. Тэр бараг ямар ч мөнгө зоосгүй болж, идэх хоолгүй болов.



Тэр маш их гайхширч, бясалгагч хөрштэйгөө ярилцахаар явав.




“Би таны Багшийг танаас агуу, илүү үнэ хүндтэй хэмээн бодон өглөг өгөхөөр очсон. Гэтэл түүнээс хойш миний ажил хэрэг маш хурдацтай уналтанд орон би өлбөрч үхэхэд хүрлээ. Ямар учраас ийм юм болов? ”




“Та надад өглөг өгөхдөө сайхан сэтгэлээр, хариу юу ч нэхэлгүйгээр өгч байсан. Тийм учир, Бурхан ч бас тантай адил хэнд өгөхөө ялгаж салгалгүй чөлөөтэйгээр өгч байжээ.”



“Гэтэл, та намайг болон миний Багшийг ялгаварлаж, Багшийг маань хамгийн дээд, таны өргөлийг хүлээн авах эрхтэй хамгийн ариун хүн гэж бодоод түүнийг сонгоход, Бурхан ч мөн тийм зүйл хийсэн. Та ялгаварласан учраас Бурхан ч мөн адил ялгаварласан юм.



Хүмүүсийг хайрлахдаа хооронд нь ялгалгүй өв тэгш хайрлах хэрэгтэй. Тэднийг чадлынхаа хэрээр хайрла. Тэдэнд бидний хэрэгцээ гарах бүрд, тэд биднийг өмнө нь бүр хохироож байсан ч хамаагүй нэн даруй туслах хэрэгтэй.





*Бусад хүмүүсийг хайрласан хүний зүрх сэтгэлд
Бурхан байдаг. Бурхны хүүхдүүдэд үйлчилнэ гэдэг нь
Бурханд үйлчилж буй хэрэг юм.*

--- Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай ---



ЖИНХЭНЭ ЭРДЭНЭ



Энэтхэгт, маш сайн нэгэн
хаан байжээ. Тэр ард
иргэддээ маш өгөөмөр
сайхнаар ханддаг байв.




Нэг өдөр тэр өөрийн бүхий л эд хөрөнгөө ард иргэддээ өгөхөөр бэлдэн тавьж гэнэ.




Хүн бүр л ирж өөр өөртөө таалагдсан юмыг авцгаав.






Хулгайч бясалгагч болсон нь



Нэгэн өдөр нэг хулгайч ордноос хулгай хийж байв гэнэ.



Тэр хоёр тайганы яриаг санаандгүй сонсчихжээ.



“Манай хаан гүнжээ ганга мөрний эрэгт байдаг бясалгагчдын нэгэнтэй нь гэрлүүлэх хүсэлтэй гэнэ. Чи үүний талаар ямар бодолтой байна?”



“Хөөх, ямар сайхан юм бэ.” хэмээн хулгайч бодов.




“Сайхан санаа байна. Бясалгагчид бол энэ дэлхийн хамгийн ариун, хамгийн эрхэм хүмүүс.”



Хулгайч нэн даруй хулгай хийхээ больж, лам болохоор шулуудан явав.





Тэр Ганга мөрний эрэгт бясалгаж буй лам нарын дунд орон суув.



Хэдэн өдрийн дараа, хаан хэдэн тайганыг Ганга мөрний зүг гүнжтэй гэрлэх хүсэлтэй ламыг олуулхаар явуулжээ.


Тэдгээр лам нар сайн бясалгагчид байсан учир, гүнжийг огт сонирхохгүй байв гэнэ.





Хэрвээ бид ариун хүмүүс, Бурханд хайртай хүмүүс гэдгээ мэдвэл Бурхан бүхнийг бидний буюу хариулалд тааруулан зохицуулна гэдгийг итгэдэг. Тэгсэнээр бид юуг ч уйх шаарлагагүй.

--- Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай ---





Энэрэнгүй сэтгэл
ба хатуу сэтгэл



Нэгийг нь Люю Пин, нөгөөг нь Ян Ли гэдэг маш сайн хоёр найз байжээ. Тэд хамтдаа Хааны засгийн газраас авдаг шалгалт өгөхөөр явав.

Люю Пин хичээнгүйлэн шалгалтандаа бэлтгэж байв.



Шалгалтын хариу гарчээ.



Ян Ли харин залхуу нэгэн байсан ба ойр зуур зугаацах дуртай байв.



Люю Пин өндөр эрдмийн зэрэг авч гэнэ.

Тэгтэл Ян Ли шалгалтандаа унажээ.

Том албан тушаалд томилогдсон Лю Пин, Ян Лиг маш гонсойж гутарч байгааг мэдэж, түүнийг дуудуулж гэнэ.



Лю Пин түүнийг хүлээн авахаар бага бичээчээ илгээжээ.



Ихэд доромжлуулсан Ян Ли ихээр бухимдан уурлав.



“Гөөх, ямар тансаг сууц вэ.”



“Ёстой нэг! Би жаахан л илүүхэн хичээх минь яав даа.”



“Сонин юм даа. Лю Пин яагаад удаад байгаа юм болоо?”



Түүнийг доод зарц нар, гуйлгагчдад өгдөг олиггүй хоолоор дайлав.



Гэртээ эргэж ирээд тэрээр ихээр сэтгэл гутарч, дахин амьдрахыг хүссэнгүй.



Гэтэл хаанаас ч юм маш үзэсгэлэнтэй, дэгжин эмэгтэй гарч ирэв.



Тэр түүний хүндрэлтэй байдлыг ойлгож, түүнийг тайтгаруулж, урам өгөв.



Эмэгтэй түүнийг оёдол эсгүүр хийн тэтгэх зуур хичээлдээ л анхаар гэж хэлжээ. Сэтгэл нь ихэд хөдөлсөн Ян Ли ихэд хичээнгүйлэн суралцжээ.




Дахин шалгалтын хариу гарч...



Ян Ли эцэст нь дээд эрдэмтний цол хүртэв.



Амжилтанд хүрсэнээ мэдмэгцээ тэрээр Лю Пингийн байранд яаран очжээ.



Хуучин найзыгаа өөдөөс уурлан зандарч гарав.



Люу Пинг туслахынхаа чихэнд нэг зүйл шивнэв...

Туслах нь нэгэн эмэгтэйг дагуулан иржээ.

Хөөе! Энэ яаж чи байж болох вэ?

Чи энд юу хийж байгаа юм бэ?

Тэр бол миний эхнэр!

Үнэндээ Ян Ли-г дордож, авьяасаа булшлахвий гэсэндээ, Люу Пинг эхнэрээ Ян Ли-г харж хандаж, урам зориг оруулахаар илгээжээ.

Ян Ли эцэст нь Люу Пиний өөрийг нь гэх хайрыг ухаарчээ. Хоёр сайн найз бие биенээ тэврэн ихэд сэтгэл хөдлөлтэйгөөр уйлцгаав.

Заримдаа, мунхаг хүний энэрэнгүй үйлдэл бусдыг хохироодог. Харин ухаантай хүний хатуу үйлдэл өөрт нь болоод бусад олон хүнд тустай байдаг. Энэ бол жинхэнэ нигүүлсэл. Тийм учраас заримдаа бид хэрхэн хатуу байхыг мэдэж байх хэрэгтэй. “Жинхэнэ сайн хүн хэзээ хатуу байж, хэзээ зөөлөн байхаа мэдэж байдаг.”

Самурайн урлаг







Самурайд (сэлмийн эрдэмд) суралцахыг ихэд хүссэн нэгэн хүн байжээ.



Эхэндээ сэлмийн багш түүнийг шавь болгон авахаас татгалзав. Тэр хүн үнэхээрийн чин сэтгэлтэй учир, гуйсаар байв. Агуу сэлмийн багш сүүлдээ үлдэхийг нь зөвшөөрчээ.



Багш нь түүний араас гэнэт бархиран, сэлмээр дайрч эхлэв.



Хоол хийж байна уу, ариун цэврийн өрөө цэвэрлэж байна уу хамаагүй, тэр үргэлжид бэлэн байдалд байв. Тэр байнгын сэрэмжтэй байхад суралцжээ.



Энэхүү шавь хожим нь хамгийн шилдэг сэлмийн багш болж, маш их алдаршжээ.



Тэгэхээр бид үргэлж бэлэн байдалд байж, сэрэмжтэй байхад суралцах хэрэгтэй. Энэ дэлхий сайн ч биш, муу ч биш. Бидэнд тустай хичээлүүдэд суралцахын тулд нөхцөл байдлыг хэрхэн ашиглахаас л энэ бүхэн хамаарна. Бид байнга суралцаж, бүх хорин дөрвөн цагийн турш бясалган дадуулж байх ёстой.






Бурхан бүхнийг зохицуулдаг

Маш их хичээнгүй нэгэн Энэтхэгийн Йогч байжээ. Түүний ээж нь маш аз жаргалтай, амар амгалан тэнгэрт хальж гэнэ.



Өвдөг сөгдөн суугаад тэрээр Бурханд ээжийг нь ийм байдлаар авч явсан ивээлд нь талархаж гэнэ.

Ээжийгээ оршуулчихаад тэр Ганга мөрний эрэг рүү явав.



Тэр өдөр бүр бясалгалдаа, Бурхантай харилцахад төвлөрч байв.



Гурван өдөр өнгөрсөн ч тэр юу ч идэж, уугагүй байлаа. Тэр идэж, уухыг бүрэн мартсан байв.




Энэ Йогч өлсгөлөнгөөс болж үхэж байгааг Бурхан хараад адистай маш их идээ будааг алтан тавган дээр тавиад, түүнд хүргүүлэхээр сахиусан тэнгэр илгээжээ.



Чимээгүйхэн, сахиусан тэнгэр түүний дэргэд хоол тавьчихаад буцан нисчээ.





Йогч ямар ч өвдөлт мэдэрсэнгүй. Хэн нэгэн яг л түүнийг гижигдэж байгаа мэт тэрээр инээдээ барьж дийлэхгүй байлаа.



Хаан ихэд сониучирхан,
алтан таваг үнэхээр
хулгайлагдсан эсэхийг
шалгахаар сүм рүү явжээ.



Сүмд очоод,
тэрээр Бурхны
хөшөөнөөс цус
гарч байхыг
олж харав.

Хөшөө яг йогчийн
цохиулсан газруудаар
цус алдаж байжээ.



Хаан йогчийг гэм зэмгүй болохыг ойлгож,
йогчийг занчих нь яг л Бурхныг занчсантай
адил болохыг ухаарчээ.



Хаан болон түүний түшмэдүүд нь бүгд ихэд айж байв.
Тэд голын эрэг рүү яаравчлан очиж,



өвдөг сөгдөн, йогчид гэмээ
наминчилжээ. Тэд мөн
түүнд өдөр бүр хоолоор
өргөл барьдаг болов.



Үүний дараа, сүм дахь
хөшөөнөөс цус гоожихоо
больжээ. Бид үнэхээр чин
сэтгэлээсээ бясалгавал
Бурхан бүхнийг зохицуулдаг
болохыг энэ үлгэрт
өгүүлж байгаа юм.



**Хөл толгойгоо
алдсан энэ дэлхий**

Эрт урьдийн цагт нэгэн агуу Гэгээрсэн Их Багш байжээ. Тэр үе үе шавиа дагуулан явж хүмүүстэй Үнэнийг хуваалцдаг байв.



Их Багш нь хоол ч гуйдаггүй маш үнэнч, цэвэр ариун нэгэн байв. Оронд нь тэрээр зэрлэг өвс ногоо, жимс идэж амь зууна. Гэвч хэсэг хугацааны дараа шавь тэсвэрлэхээ байжээ!



Нэгэн өдөр шавь нь хоол гуйхаар ганцаараа хот оржээ. Тэгээд тэрээр хүү төрсний баяр тэмдэглэж байгаа нэгэн гэр бүлтэй таарав.



Өөрөө цадатлаа идээд, Багшдаа хэсэг хоол авчран өгчээ.

Тэр шинээр төрсөн хүү бол тэдний дайсан нь, тэднээс авлагатай нэгэн. Тэр авлагаа авахаар ирсэн. Тэмдэглэх юм юу ч байхгүй!



Тэр гэр бүл хүүхэдтэй болоод маш их жаргалтай байсан! Багш юунд ийм зүйл ярина вэ?





Дараагийн өдөр нь шавь хоол авах горьдлого тээн нөгөө айл руугаа дахин явжээ.

Байшинд ормогц тэр хүн бүр балмагдан уйлцгааж байхыг олж харав.



Багшаа!
Ямар нэгэн муу юм боллоо. Шинэ төрсөн хүүхэд үхчихэж!

Ха!
Ха!
Ха!

Багшаа, Та юунд инээнэ вэ? Хүмүүс өөд болсон нялх хүүхдийнхээ араас гашуудаж байхад та юунд инээнэ вэ?



Энэ бол хөл толгойгоо алдсан (эсэргээрээ) дэлхий. Өчигдөр тэдний дайсан ирсэн, харин өнөөдөр тэр явчихсан!

Тэр нялх хүүхэд өмнөх төрөлдээ энэ гэр бүлийн хөрш нь байсан юм. Тэрээр энэ гэр бүлд хэсэг мөнгө зээлдүүлснийг тэд эргүүлэн төлөөгүй ба хожим нь энэ гэр бүл баян болсон ч өр төлбөрөө бүрэн мартсан байв. Тэрхүү хөрш нь өөд болсныхоо дараа, энэ гэр бүлийн хүү нь болон мэндэлж, тэдний бүх эд хөрөнгийг үгүй хийх төлөвлөгөөтэй байжээ. Гэр бүл түүнд өртэй байсан мөнгөө найр хийн үрсэн бөгөөд нэгэнт өр төлөгдсөн учраас тэр хүүхдэд энэ дэлхийд байх ямар ч шалтгаан үлдээгүй юм.



**Бүх зүйл бодлоос
үүдэлтэй**

Хоёр найз хамтдаа гадуур явж байв. Нэгэн сүмийн дэргэдүүр өнгөрөх зураа тэд хэн нэгэн Энэтхэгийн маш алдартай ариун судар болох “Бхагавад Гита”-г уншиж байхыг сонсжээ.

Алив! Дотор орж ариун сургаалыг сонсоцгооё.




Хэсэг зуур сонссоныхоо дараа нэг нь гарч явжээ.



Тэр охидуудтай сээтэгнэхээр үдэшлэгт очжээ. Төд удалгүй, тэрээр уйдаж, мөн маш ихээр харамсаж, ичиж байв.




Тэр сүмрүү яаран буцсан боловч судрын уншлага хэдийнэ дууссан байв.



Гэртээ харьсныхаа дараа тэр харамсаж, хэдэн өдөр гүнээ гэмшжээ...



Харин энэ хооронд, сүмд үлдсэн түүний найз нь үдэшлэг болоод найзыгаа бодсоор байсан тул сударт төвлөрч чадахгүй байв.



Хэдэн жилийн дараа тэд хоёулаа өөд болжээ.



Үдэшлэгт явсан найз нь Диваажинд хүргэгдэв...

Харин сүмд үлдэж судар сонссон найзыг нь үхлийн элч там руу чирэн унагаажээ.



Бүх юм сэтгэлээс үүдэлтэй учраас ийм зүйл тохиолджээ.” Бурхан зөвхөн бидний үйлдлийг хараад зогсохгүй Тэрээр мөн бидний зүрх сэтгэлийг хардаг.

ОЮУН УХААНАА САЙН АШИГЛА





Нэгэн сүнслэг бясалгач тамд зочлон, нэгэн чөтгөр тамын галаар ширүүхэн шатаалгаж байхыг олж харжээ.

Тэрээр Газрын Зүрхэн Бодисадвагаас асуув:

Ягаад тэр тамын галаар ийм аймшигтай шийтгүүлж байгаа юм бэ?

Энэ хүн бол туйлын муу хүн! Бид түүний догшин хэрцгий зүрх сэтгэлийг галаар сөнөөх ёстой. Тэгснээр түүний сайн сайхан чанар нь хожим нь илрэх боломжтой болох юм.

Бясалгач чөтгөрийг ихэд өрөвдсөн учраас Бодисадвагаас чөтгөрийг харж хандуулахаар түүнд өгч явуулахыг хүсчээ.



*Газрын Зүрхэн Бодисадва бол үүрдийн тамд байгаа төрөлтнүүдийн зовлонг арилгахад туслана гэж Бурханд амласан домогт Буддын шашны гэгээнтэн юм.

Чи өөртөө асуудал тарих нь дээ. Гэвч чи үнэхээр чин сэтгэлтэй байгаа учраас түүнийг авч харихыг чинь өвшөөрье.




Гэртээ тэрээр чөтгөрт маш их хийх ажил өгчээ. Чөтгөр баяртай байв. Тэр хийх ажилтай л байвал ямар ч асуудал тарихгүй байв.



Гэвч удалгүй бүх ажил дуусч, тэр эзнээсээ нэмж ажил шаарджээ...

Гэвч хийх ямар ч ажил байхгүй байв!

Тэгтэл чөтгөр эзэнтэйгээ маргалдав!



Тэр бүр түүнийг хөнөөхийг хүсчээ. Чөтгөр маш агуу хүч агуулж байсан ч хэрхэн ашиглахаа мэдэхгүй байв.

Үхтлээ айсан эзэн нь тамруу зугтан очиж, Бодисадвагаас аврал хайв.



Энэ асуудлыг чи өөрөө бий болгосон! Гэртээ хариад түүнд маш урт, өндөр шаттай аврага том цамхаг барь гэж хэл.



Цамхаг баригджээ!

Чөтгөр дахиад л уйтгарлажээ.



Дахиад л тэр илүү хийх ажил шаардан эзнээ хөнөөхийг оролдон, элдэн хөөв.

Эзэн нь дахиад л Бодисадвагаас тусламж эрэв.

Түүнд шатны хамгийн доороос хамгийн дээд шат хүртэл өдөр бүр авирч, буцан бууж ир гэж хэл!



Үнэхээр, жижиг чөтгөр дахин эзнээ үймүүлсэнгүй.

Бидний тархи яг үүнтэй л адил. Хэрвээ хийх ажилгүй бол, утгагүй зүйлс боддог. Бид үнэ цэнээ мэдэж, дэмий үрэх учиргүй. Бид нийгэмд үйлчилдэг ажил сонгох учиртай. Сэтгэл хөдлөлөөр хандаж буруу сонголт хийж, авьяас чадвар, хүч чадлаа дэмий бүү үрээрэй.

Мунхаг Ханхүү



Эрт урьдын цагт өөрийгөө тахиа хэмээн боддог нэгэн ханхүү байжээ. Өдөр бүр тэр юу ч өмсөлгүй газраас хоол хайн явдаг байв.

Би бол тахиа.

Хаан олон алдартай эмч нартай ярилцсан боловч аль нь ч ханхүүг анагааж чадсангүй.

Өөө!

Нэгэн өдөр сүнслэг бясалгач хаантай уулзахаар иржээ...

Та ханхүүг эдгээж чадах уу?

Тийм, гэхдээ та надад түүнийг бүрэн даатгах хэрэгтэй!

Яг л ханхүү шиг авирлаж, сүнслэг бясалгач мөн юу ч өмсөлгүй газраас хоол ангуучилдаг болов.

Чи хэн бэ?

Би бол тахиа!



Тэд өдөр бүр хамтдаа амьдарч, ханхүү түүнд улам бүр итгэж байв.

Хэсэг хугацааны дараа бясалгагч хаанаас хоёр цамц авчрахыг хүсэв.



Тахиа цамц өмсөж болохгүй гэж хэн хэлсэн юм?

За, чи цамц өмсөж байгаа юм бол би ч бас цамц өмсмөөр байна!

Тахиа өмд өмсөж болохгүй гэж хэн хэлсэн юм?

Энэ хөгжилтэй юм аа. Би ч бас өмд өмсмөөр байна.

Хэсэг хугацааны дараа, тэр хаанаас хоёр өмд илгээхийг хүсэв.



Төд удалгүй, тэр хаанаас ширээ дүүрэн хоол бэлдэхийг хүсэв.



Тахиа биднийг ширээний ард хүндтэйгээр суун хоол идэж болохгүй гэж хэн хэлсэн юм?



Мөн л ханхүү түүний үйлдлийг дуурайв.



Алхам алхамаар ханхүү аажмаар энгийн хүний амьдралдаа оржээ!

Үүнтэй адилаар Гэгээрсэн Их Багш хамаг төрөлтнүүдийн дунд амьдарч, бидний ташаа үзэл баримтлал, муу зуршлуудыг засахын тулд хүлээцтэй ханддаг. Дараа нь бид Гэгээнтний дээд чанаруудыг сурч болно.

"Би" үзлийн сорилт



Нэгэн өдөр төгс, агуу Их Багш шавьдаа зааварчилгаа өгчээ...

Яваад хоёр төмс аваад ир.

За, Багшаа!

Одоо, энэ хоёр төмсөө ид.

За, Багшаа!

Хоёуланг нь идээрэй!

Хоёр төмс идэхэд үнэхээр амархан, хэцүү сорилт биш!

Багшийнх нь хэлсэн бүхэн учир шалтгаантай байдаг бөгөөд заавал гүйцэлдүүлэх ёстой гэдгийг ухаарахуйц хэмжээнд Багшийгаа тэрээр удаан дагажээ.

Эхний төмсөө идэж дуусахад, нэгэн гуйлгачин ирэв.



Наад төмсөө надад өгөөч! Хэдэн өдөр би юу ч идсэнгүй!



Хэрвээ наад төмсөө надад идүүлэхгүй бол, би үхнэ!

Хоёр төмсийг хоёуланг нь ид гэж Багш шаардсан нь үнэн боловч сүнслэг бясалгачийн хувьд би яаж үхэж байгаа хүнийг аврахгүй байж болох билээ?



За, за! Чи авдаа!



Чи үнэхээр мулгуу юм! Магадгүй энэ чиний хувь тавилан байх! Багшийнхаа оронд "Би" үзлээ сонссон чинь ямар харамсалтай хэрэг вэ!



Эхний төмс бол ертөнцийн амжилт, нэр алдар, эд баялагаар адислагдсан байсан юм.



Хоёр дахь төмс нь хамгийн дээд, туйлын гэгээрэлд хүрэх агуу сүнслэг ололтоор адислагдсан байсан юм.



Гэгээрсэн Их Багш нь жинхэнэ билиг ухааныг, харин "Би" үзэл нь бидний урьдчилан төсөөлсөн үзэл бодлыг илэрхийлжээ. Бидний хараа булингартаж; зөвхөн талыг нь л хардаг, эсвэл магадгүй юу ч хардаггүй байж бид зөв буруу бүхнийг мэднэ гэж боддог.



Сэтгэлийн огоорол л чухал





Нэгэн өдөр, нэгэн Их Багш шавьдаа өөр газар даяан хийж суугаа хүнд хоол хүргээд ир гэж хэлжээ.

Гэхдээ тэр хүн чинь голын нөгөө эрэгт байдаг шүү дээ. Би сэлж чадахгүй, мөн ямар ч завь байхгүй! Би яаж гол гатлах вэ? Надад танд байдаг шиг агуу шидийн хүч байхгүй.



Голын эрэгт хүрээд, голд ингэж хэлээрэй: "Хурдхан усаа тусгаарлаж, намайг гатлуулна уу. Би энд хэзээ ч эмэгтэй хүнтэй ойртож байгаагүй Их Багшийнхаа захиасаар ирлээ."



Аан!



Хачин юм даа! Их Багш маань эхнэр, гурван хүүхэдтэй. Тэр яаж ингэж хэлж чадна вэ? Худал хэлнэ гэдэг сахил зөрчсөн болох бишүү?




Тэр Багшаасаа асууж зүрхэлсэнгүй. Тэгээд ч түүний Багш нь тэгж хэлсэн л бол ингэх шалтгаантай байж л таараа. Тиймээс тэр нэн даруй хоол хүргэхээр замд гарчээ.



Голын эрэгт хүрээд, голд ийнхүү хэлжээ:



Үүний дагуу тэрээр тэдгээр
үгсийг гол руу хашхиран хэлэхэд
голын ус дахиад л голоороо
хуваагдав!



Түүний хувьд энэ үнэхээр
гайхалтай байлаа. Тиймээс
тэр эргэж ирээд Багшийнхаа
тайлбарлахыг хүсэн асуужээ.



Чиний харж байгаа зүйл чинь зөвхөн
миний гадаад төрх боловч зүрх
сэтгэл минь биш. Гаднаа би эхнэр
хүүхдүүдтэй ч миний зүрх сэтгэл,
миний жинхэнэ хүн энд байхгүй.
Би юунд ч хүлээсгүй.
Даяан хийж байгаа
найзын маань хувьд
хоол хэзээ ч идэж
байгаагүй гэж хэлсэн нь
бас үнэн юм. Олон хүнд
тэр энд хэрэгтэй учраас махан
бие амьд байлгахын тулд тэр иддэг.
Тэр огтхон ч хоолонд хорхойсоогүй, идэх
гэж дурладаггүй!



“Би зөвхөн үнэн зүйлсийг хэлдэг
учраас миний хэлсэн үгсэд хүч бий.
Мөн чи миний зааварчилгааг дагасан
учраас, адил хүч дамжуулагдсан юм.



**Гэгээрсэн төрөлтнүүд
мөнхийн тогтуун
байдаг Дао –той (Үнэн)-тэй
үргэлжийн мөнх хамт байдаг.
Тэд яг л энгийн хүмүүстэй
адил юмсыг хийдэг ч үнэндээ
тэд үйлдэлд хамааралгүй
хөндлөнгөөс нь харж
байгаа ажиглагч нар шиг л
юм.**



